



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/163

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын 1.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа орон нутгийн нисэх буудлууд, “Чингис хаан” Олон улсын нисэх буудал болон Хөшигийн хөндийд шинээр баригдсан Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг нэгдсэн бодлого, удирдлагаар хангаж, аж ахуйн тооцооны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах зорилготой хуулийн этгээд шинээр байгуулах боломжийг судалж, санал боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	Д.Эрдэнэбаатар	Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Өнөрболд	Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Нисэх буудлыг үйл ажиллагаанд бэлтгэх хэсгийн ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Д.Баясгалан	Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны ахлах эдийн засагч
	Б.Энх-Амгалан	Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Ч.Одгэрэл	Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Д.Төгсбаяр	“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Үйлдвэрлэлийн төлөвлөлт, зохицуулалт, хяналтын хэлтсийн дарга

08 0610

Н.Мягмарсүрэн	Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны дэд бүтэц, техник ашиглалт хариуцсан дэд дарга
А.Азбилэг	Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Нисэх буудлыг үйл ажиллагаанд бэлтгэх хэсгийн дарга
Ц.Цэвээндаш	Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Нисэх буудлыг үйл ажиллагаанд бэлтгэх хэсгийн ахлах мэргэжилтэн
Х.Саруул	Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Нисэх буудлыг үйл ажиллагаанд бэлтгэх хэсгийн ахлах мэргэжилтэн
Б.Баттөр	Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Нисэх буудлыг үйл ажиллагаанд бэлтгэх хэсгийн мэргэжилтэн
Д.Очирсүрэн	Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Барилга, байгууламжийн засвар, арчлалтын хэсгийн ахлах инженер

2. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.


3. Ажлын хэсгийн саналыг 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн дотор Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлагад танилцуулах, гишүүдийг шаардлагатай тохиолдолд үндсэн ажил үүргээс түр чөлөөлж, ажлын хэсгийг зохион байгуулан ажиллахыг Ажлын хэсэг /Д.Эрдэнэбаатар/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2018 оны 13 дугаар сарын 25-ны өдрийн
А/163 дугаар тушаалын хавсралт



**НИСЭХ БУУДЛУУДЫГ НЭГДСЭН БОДЛОГО, УДИРДЛАГААР ХАНГАХ
ХУУЛИЙН ЭТГЭЭД БАЙГУУЛАХ БОЛОМЖИЙГ СУДАЛЖ, САНАЛ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ**

Зорилго: Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын зөвлөмжийн дагуу иргэний нисэхийн салбарт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шаардлагыг хангахуйц бүтцийн шинэчлэл хийх ажлын хүрээнд нисэх буудлуудын үйл ажиллагааг аж ахуйн тооцоот хэлбэрт шилжүүлэн, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий хуулийн этгээд байгуулах, хэрэгжих боломжийг судлан санал боловсруулах.

Ажлын хэсгийн гүйцэтгэх ажил: Ажлын хэсэг нь нисэх буудлуудыг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах зорилготой хуулийн этгээд байгуулах асуудлыг судлах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Хуулийн этгээдийн хэлбэрийг тодорхойлж, холбогдох хууль эрх зүйн үндэслэлийг боловсруулах;
2. Хуулийн этгээд байгуулах үе шатыг тодорхойлж, шаардлагатай эрх зүйн баримт бичиг (хууль, дүрмийн өөрчлөлт, тогтоол, тушаал, шийдвэр гэх мэт)-ийн жагсаалтыг гарган, эрх зүйн баримт бичгүүдийн төслийг боловсруулах;
3. Хуулийн этгээдийн цаашид эрхлэн явуулах үйл ажиллагаа, цар хүрээг тодорхойлж, түүнд тохирсон оновчтой бүтэц, зохион байгуулалт, орон тооны төсөл боловсруулах;
4. Орон нутгийн нисэх буудлууд болон Буянт-Ухаа дахь "Чингис хаан" олон улсын нисэх буудалд ашиглаж байгаа өмч, хөрөнгийн бүртгэлийг нэгтгэн, шинээр байгуулах хуулийн этгээдийн өмчлөлд шилжүүлэх өмч, хөрөнгийн төрлийг тодорхойлох;
5. Шинээр байгуулах хуулийн этгээдийн үйл ажиллагаа, түүнээс олох орлогын эх үүсвэр, зардлын бүтцийг тодорхойлж, тогтвортой үйл ажиллагаа явуулахад шаардлагатай төсөв, хөрөнгийн хэмжээг тодорхойлох;
6. Хуулийн этгээдийн үйл ажиллагааг тогтворжуулах, хэвийн явуулах нөхцлийг хангахад шаардлагатай зардлыг санхүүжүүлэх зарчмыг хуульд нийцүүлэн боловсруулж, санал гаргах;
7. Ажлын тайлан, саналыг боловсруулж Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлагад танилцуулах.